



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 7/116

Мандалговь

Цахим хуудас хөгжүүлэлтийн ажлын
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйл, Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 49 дүгээр тогтоол, Төрийн байгууллагуудын цахим хуудсанд тавигдах MNS 6285:2011 стандарт, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын төрийн байгууллагуудын нэгдсэн цахим хуудас шинэчлэгдсэнтэй холбогдуулан цахим хуудасны мэдээллийг тогтмол шинэчлэх, хөгжүүлэлтийг хариуцан ажиллах, хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ц.Лхагвасүрэн (Тамгын газрын дарга)

Гишүүд: Сургуулийн захирлууд

Цэцэрлэгийн эрхлэгч нар

Эрүүл мэндийн төвийн дарга нар

О.Уранзаяа (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Багийн Засаг дарга нар

З.Алтаншагай (Хууль, эрх зүйн мэргэжилтэн)

Э.Цэрэннадмид (Дотоод ажилтан)


Б.Уранжаргал (Санхүү албаны дарга)

Нарийн бичгийн дарга: Б.Мөнхбаяр (Хэвлэл мэдээллийн ажилтан)

2. Ажлын хэсгийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Хариуцсан ажил үүргийн хуваарийн дагуу цахим хуудсанд мэдээллийг тогтмол оруулж, мэдээллийн чанар, хугацаанд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсэг (Ц.Лхагвасүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.БАТ-ОРГИЛ

ID/document /Zasagdarga/ A.Zahiramj .doc 04.24

2023010761